



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Дархлаажуулах арга хэмжээ
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Дархлаажуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.12 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Пневмококкийн шалтгаант уушгины хатгалгаа өвчнөөс сэргийлэх пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар дархлаажуулах Үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, Дархлаажуулах товыг хоёрдугаар, Вакциныг хэрэглэх зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийслэлийн Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн 2 сартай хүүхдийг пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар дархлаажуулах арга хэмжээг товын дагуу 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Нийслэлийн эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

3. Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины ач холбогдлыг эрүүл мэндийн ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад олон нийтийн мэдээллийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Б.Цогтбаатар/, Нийслэлийн эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
 2018 оны 01 сарын 26 -ны өдрийн
 А/20 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ПНЕВМОКОККИЙН ЭСРЭГ 13 ЦЭНТ (ПЭВ13)-ЫН ВАКЦИНААР ДАРХЛААЖУУЛАХ
 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран гүйцэтгэх
1	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн 2 сартай хүүхдийн судалгааг нарийвчлан гаргах	2018 оны 02 дугаар сард	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, ӨЭМТ	НЭМГ, ХӨСҮТ
2	ПЭВ13 вакцин, дагалдах хэрэгслийг дүүргүүдэд хуваарилах	2018 оны 02 дугаар сард	ХӨСҮТ	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ
3	Өрхийн ЭМТ, дүүргийн НЭ-ийн эмч сувилагч нарыг ПЭВ13 вакцинаар дархлаажуулах талаар арга зүйн сургалт зохион байгуулах	2018 оны 01,02 дугаар сард	ХӨСҮТ	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ
4	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн 2 сартай хүүхдийг ПЭВ13 вакцинаар товын дагуу дархлаажуулах	2018 оны 03 дугаар сараас эхлэн тогтмол	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, ӨЭМТ	НЭМГ, ХӨСҮТ
5	Вакцины товын талаар эрүүл мэндийн ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлэл, зөвлөмж хүргүүлэх	2018 оны 02 дугаар сард	ХӨСҮТ	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ

6	(ПЭВ13) вакцин бусад вакцинтай хэрхэн зэрэг хийх, өвдөлтгүй тарих арга технологийн талаар сургалтыг вакцилятор сувилагч нарыг ажлын байранд дадлагажуулах	2018 оны 02 дугаар сард	ХӨСҮТ	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ
7	Дархлаажуулалтын үйлчилгээнд баримтлах эмч, эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа зөвлөгөө өгөх ур чадварын сургалт зохион байгуулах	2018 оны 02 дугаар сард	ХӨСҮТ	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ
8	Дархлаажуулалтын товоос хоцорсон хүүхдийг нөхөн дархлаажуулах арга зүйн зөвлөмж гарган сурталчлах	2018 оны 03 дугаар сараас эхлэн тогтмол	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, ӨЭМТ	НЭМГ, ХӨСҮТ
9	ПЭВ13 вакцины хамралтыг цахим бүртгэлийн программд оруулах талаар ӨЭМТ-ийн эмч, сувилагч нарт ажлын байрны сургалт зохион байгуулах	2018 оны 02 дугаар сард	ХӨСҮТ	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ
10	Дархлаажуулалтын нэгжийн үйл ажиллагаа, дархлаажуулалтын явцад дэмжлэгт хяналт хийх, ажлын байранд сургалт зохион байгуулах	2018 оны 02 дугаар сараас эхлэн долоо хоног бүр	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ	ХӨСҮТ
11	Эрүүл мэндийн ажилтан, эцэг эх, асран хамгаалагчид зориулсан гарын авлага боловсруулах, зурагт хуудас түгээх	2018 оны 02, 03 дугаар сард	ХӨСҮТ	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ
12	Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалт хийж эргэн мэдээллээр хангах	2018 оны 02 дугаар сараас эхлэн долоо хоног бүр	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ	ХӨСҮТ

13	Дархлаажуулалтын хамралтын мэдээллийг олон нийтийн сүлжээ, цахим хуудсаар сурталчлах	2018 оны 03 дугаар сард	ХӨСҮТ	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ
14	Өрхийн ЭМТ, дүүргийн НЭ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд давтан сургалт зохион байгуулах	2018 оны 03-04 дүгээр сард	ХӨСҮТ	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ
15	Вакцины ач холбогдлын талаар инфографик, урсдаг зар бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	2018 оны 03 сараас эхлэн сар бүр	ХӨСҮТ	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ
16	Дархлаажуулалтын явцын болон хамралтын тайланг гарган Дархлаажуулалтын зөвлөх хорооны хурлаар хэлэлцүүлэх.	2018 оны 12 дугаар сард	ХӨСҮТ	Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЭМТ, НЭМГ

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 01 сарын 26-ны өдрийн
А/20 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ПНЕВМОКОККИЙН ЭСРЭГ 13 ЦЭНТ ВАКЦИНААР ДАРХЛААЖУУЛАХ ТОВ

1. Товлолын дагуу пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин (ПЭВ13)-ы дархлаажуулах тов

Дархлаажуулах нас	2018 оны 03 дугаар сар	2018 оны 05 дугаар сар	2018 оны 10 дугаар сар
2 сар	ПЭВ13 вакцины 1 дэх тунг Тавт вакцины 1 дэх тунтай нэгэн зэрэг		
4 сар*		ПЭВ13 вакцины 2 дахь тунг Тавт вакцины 3 дахь тунтай нэгэн зэрэг	
9 сар**			ПЭВ13 вакцины 3 дахь тунг Улаанбурхангахай хавдарулаануудын эсрэг (УГУ) вакцины 1 дэх тунтай нэгэн зэрэг

Тайлбар: 2018 оны 2 дугаар сард 2 сартай хүүхдийг эхний тунгаар дархлаажуулна.

*- ПЭВ13 вакцины 1-р тунд хамрагдсан хүүхэд

** - ПЭВ13 вакцины 1 ба 2-р тунд хамрагдсан хүүхэд

-oOo-

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 01 сарын 26 ны өдрийн
А/20 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



ПНЕВМОКОККИЙН ЭСРЭГ 13 ЦЭНТ ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Найрлага

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин нь *Streptococcus pneumoniae* нянгийн 13 дэд хэв шинжийн (1, 3, 4, 5, 6A, 6B, 7F, 9V, 14, 18C, 19A, 19F, 23F) гадаргуугийн эсрэгтөрөгчийн сахарид, сахуугийн CRB197 уураг, сахуугийн хоргүйсүүр, хөнгөн цагааны фосфат агуулсан.

0.5 мл нэг хүн тун вакцинд:

Пневмококкийн (1, 3, 4, 5, 6A, 7F, 9V, 14, 18C, 19A, 19F, 23F)

дэд хэвшинжийн полисахаридууд

2.2 μ г тус бүр

Пневмококкийн 6B дэд хэвшинжийн полисахарид

4.4 μ г

Сахуугийн CRM₁₉₇ уураг

-34 μ г

Хөнгөнцагааны фосфат

0.125 мг

Бусад найрлага: Полисорбит 80, Содиум хлорид.

Савлалт

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин нь шингэн хэлбэртэй цагаан өнгийн цийдмэг. Нэг флаконд 0.5мл-1 хүн тунгаар савлагдсан.

Тарих тун хэмжээ, тов, бусад вакцинтай харилцан үйлчлэл

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакциныг 3 тун хийлгэх шаардлагатай. Эхний тунг 2 сартай, хоёр дахь тунг 4 сартай, гурав дахь тунг 9 сартайд нь тус тус хийнэ.

Булчинд тарьж хэрэглэнэ. Нярай хүүхдэд гуяны гадна дунд хэсэгт, 9-с дээш сартай хүүхдэд бугалганы делтойд булчинд тарина. Тарихаасаа өмнө вакциныг зөөлөн сэгсэрч, нэгэн жигд суспенз болгосны дараа хэрэглэнэ. Нэг удаагийн ариун зүү тариур хэрэглэн 0,5 мл тунгаар булчинд тарина. Вакциныг өгзөгний булчинд тарихгүй.

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакциныг сахуу, хөхүүл ханиад, татран, В хэвшинжийн хемофилюс инфлюэнза (Хиб), гепатит В, улаанбурхан, улаанууд, гахайн хавдар, С хүрээний менингококкт халдвараас сэргийлэх болон халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинтай нэгэн зэрэг дархлаажуулж болно.

Хэрвээ нэгэн зэрэг хийгээгүй тохиолдолд нэг сарын дараа нөхөн дархлаажуулна. Хүний дархлал хомсдолын вирусын халдвартай хүнд хийж болно.

Пневмококкийн эсрэг 7 цэнт вакцин хийлгэсэн хүүхдэд:

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин нь (пневмококкийн эсрэг 7 цэнт) вакцинд агуулагддаг 7 хэв шинжийг агуулсан ба адилхан CRM197 уургийг ашиглан конъюгат (нийлмэл) технологиор үйлдвэрлэсэн.

Өмнө нь пневмококкийн эсрэг 7 цэнт вакцинаар дархлаажуулсан хүүхдийг товлолын дагуу пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар дархлаажуулж болно.

Дархлаажуулалтын дараах урвал:

Хэсэг газрын урвал болон халуурах, цочромтгой болох, нойрмоглох, тайван бус болох, хоолонд дургүй болох, бөөлжих, суулгах, тууралт гарах зэрэг шинжүүд гарч болно.

Эсрэг заалт:

Вакцины найрлагад орсон бодис болон сахуугийн хоргүйсүүрт хэт мэдрэг хүүхдэд тарихгүй.

Хадгалах, тээвэрлэх:

Вакциныг $+2^{\circ}\text{C}$ $+8^{\circ}\text{C}$ -д тээвэрлэж, хадгална. Хөлдөөж болохгүй, хэрэв хөлдсөн тохиолдолд хэрэглэхгүй.

Үйлдвэрлэсэн: Пизер лимитед сэндвич, Их Британи улс